

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/97/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99900662 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.20 № 01/91
танай _____-ны № _____-т

ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.НЯМХАНД ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 12,433.0 мянган төгрөгийн 4 мотоцикл, ОНХС-ийн хөрөнгөөр 68,360.0 мянган төгрөгийн ковш, 15,000.0 мянган төгрөгийн мах ногоо борлуулах байр, 18,000.0 мянган төгрөгийн ухаалаг худаг зэрэг хөрөнгүүдийг хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын Санхүүгийн байдлын тайланд 121,853.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй боловч элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй 173 ширхэг үндсэн хөрөнгийг тайлагнасан байна. Гэвч үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгүүдийг дахин үнэлэх, цаашид ашиглах боломжгүй бол данснаас хасах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Засаг даргын Тамгын газрын дарга нь сумын Засаг даргатай 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 96.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	117,390,085.00	150,823,434.94
33	АВЛАГА	00.00	2,041,049.94
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	164,908.79
335	Бусад авлага	00.00	1,876,141.15
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,876,141.15
35	БАРАА МАТЕРИАЛ	117,390,085.00	148,782,385.00
351	Түүхий эд материал	6,387,650.00	5,926,150.00
35110	Тусгай зориулалттай материал	6,387,650.00	5,926,150.00
354	Хангамжийн материал	107,752,435.00	138,966,235.00
35410	Бичиг хэргийн материал	721,500.00	833,500.00
35420	Аж ахуйн материал	13,476,148.00	13,943,148.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	2,215,100.00
35440	Түлш, шатах тослох материал	4,015,700.00	00.00
35450	Барилгын засварын материал	236,400.00	236,400.00
35470	Бусад хангамжийн материал	89,302,687.00	121,738,087.00
35600	Мал амьтад	3,250,000.00	3,890,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	891,745,990.74	978,700,265.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	891,745,990.74	978,700,265.92
392	Биет хөрөнгө	861,892,193.48	949,363,968.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	586,012,076.00	601,012,076.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-130,690,975.93	-145,819,760.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100,565,800.00	181,359,133.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,333,398.25	-59,813,451.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	165,445,988.86	219,021,116.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44,028,456.41	-66,983,602.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,982,340.77	32,032,340.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,490,530.37	-12,674,329.06
39209	Зам, гүүрийн байгууламж	330,780,254.91	330,780,254.91
39210	Хуримтлагдсан элэгдэл	-151,721,481.10	-164,188,616.08
39214	Бусад үндсэн хөрөнгө	50,722,500.04	65,072,500.04
39215	Хуримтлагдсан элэгдэл	-27,351,925.04	-30,433,693.16
393	Биет бус хөрөнгө	29,853,797.26	29,336,297.35
39301	Програм хангамж	2,680,000.00	2,680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-517,499.91
39303	Бусад биет бус хөрөнгө	27,173,797.26	27,173,797.26
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,009,136,075.74	1,129,523,700.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,200,000.00	868,600.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,200,000.00	868,600.00
413	Өглөг	7,200,000.00	868,600.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	189,400.00
4136	Бусад өглөг	7,200,000.00	679,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	7,200,000.00	679,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,001,936,075.74	1,128,655,100.86
51	Засгийн газрын хувь оролцоо	1,001,936,075.74	1,128,655,100.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	415,830,761.84	415,830,761.84
51101	Өмч: - төрийн	415,830,761.84	415,830,761.84
512	Хуримтлагдсан үр дүн	466,751,731.91	593,470,757.03
51210	Өмнөх үеийн үр дүн	466,751,731.91	466,751,731.91
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	126,719,025.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	119,353,581.99	119,353,581.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,009,136,075.74	1,129,523,700.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	771,491,240.00	673,416,311.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	362,698,457.00	223,550,361.00
120	Нийтлэг татварын бус орлого	362,698,457.00	223,550,361.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	356,341,257.00	158,747,961.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	240,000.00	49,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	408,792,783.00	449,865,950.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,702,583.00	28,420,150.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	500,000.00	620,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,462,583.00	4,340,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,740,000.00	23,459,350.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	398,090,200.00	421,445,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	398,090,200.00	421,445,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	460,573,628.17	543,937,285.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	460,573,628.17	543,937,285.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,279,855.33	505,420,148.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,317,615.96	259,232,485.57
210101	Үндсэн цалин	252,317,615.96	204,035,433.95
210102	Нэмэгдэл	00.00	39,262,207.62
210104	Урамшуулал	00.00	15,934,844.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,609,841.37	32,410,240.46
210201	Тэтгэврийн даатгал	23,516,734.97	22,206,210.02
210202	Тэтгэмжийн даатгал	2,523,101.60	2,551,007.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,018,481.23	2,040,866.43
210204	Ажилгүйдлийн даатгал	504,620.37	510,141.86
210205	Эрүүл мэндийн даатгал	5,046,903.20	5,102,014.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,154,713.83	29,437,739.82
210301	Гэрэл, цахилгаан	2,068,246.83	2,455,585.82
210302	Түлш, халаалт	28,086,467.00	26,897,154.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	85,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,980,871.00	31,244,145.68
210401	Бичиг хэрэг	3,015,000.00	4,445,199.68
210402	Тээвэр, шатахуун	10,458,427.00	18,930,125.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,709,974.00	4,305,611.00
210404	Ном, хэвлэл	46,500.00	274,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,056,920.00	827,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,694,050.00	2,461,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	2,883,550.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	2,883,550.00
2107	Томилолт, зочны зардал	900,000.00	940,000.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	940,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,904,800.00	39,686,591.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,963,400.00	38,522,788.00
210803	Даатгалын үйлчилгээ	172,740.00	66,000.00

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	132,674.00	247,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	22,829.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478,500.00	687,500.00
210807	Газрын төлбөр	69,486.00	140,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,412,013.17	109,585,395.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,234,880.00	30,771,210.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	78,177,133.17	78,814,185.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,293,772.84	38,517,137.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,636,706.00	16,508,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	15,432,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,863,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,272,906.00	1,075,500.00
2134	Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,657,066.84	22,008,837.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,657,066.84	22,008,837.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	310,917,611.83	129,479,025.12
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,250,000.00	2,760,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,250,000.00	-2,760,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	307,667,611.83	126,719,025.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	411,572,683.00	450,915,450.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,240,000.00	1,049,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,240,000.00	1,049,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,240,000.00	1,049,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	240,000.00	49,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	410,332,683.00	449,865,950.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,242,483.00	28,420,150.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	500,000.00	620,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,462,583.00	4,340,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,279,900.00	23,459,350.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	398,090,200.00	421,445,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	398,090,200.00	421,445,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	398,350,983.00	442,845,450.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	398,350,983.00	442,845,450.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	378,057,210.16	402,452,171.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,357,515.96	259,232,485.57
210101	Үндсэн цалин	252,357,515.96	204,035,433.95
210102	Нэмэгдэл	00.00	39,262,207.62
210104	Урамшуулал	00.00	15,934,844.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,609,841.37	32,575,149.25
210201	Тэтгэврийн даатгал	23,516,734.97	22,371,118.81
210202	Тэтгэмжийн даатгал	2,523,101.60	2,551,007.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,018,481.23	2,040,866.43
210204	Ажилгүйдлийн даатгал	504,620.37	510,141.86
210205	Эрүүл мэндийн даатгал	5,046,903.20	5,102,014.85

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,154,713.83	29,315,052.50
210301	Гэрэл, цахилгаан	2,068,246.83	2,332,898.50
210302	Түлш, халаалт	28,086,467.00	26,897,154.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	85,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,673,195.00	25,716,671.00
210401	Бичиг хэрэг	3,388,000.00	2,535,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,474,126.00	15,554,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,079,049.00	4,305,611.00
210404	Ном, хэвлэл	46,500.00	274,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,056,920.00	712,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,628,600.00	2,334,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,790,000.00	4,872,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,000.00	00.00
210602	Тавилга	1,710,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,872,200.00
2107	Томилолт, зочны зардал	900,000.00	940,000.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	940,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,671,944.00	19,510,903.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,650,544.00	18,267,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	172,740.00	66,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	132,674.00	247,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	22,829.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	558,500.00	767,500.00
210807	Газрын төлбөр	69,486.00	140,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,900,000.00	30,289,710.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,900,000.00	30,289,710.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,293,772.84	40,393,278.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,636,706.00	16,508,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	15,432,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,863,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,272,906.00	1,075,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,657,066.84	23,884,978.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,657,066.84	23,884,978.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>13,221,700.00</u>	<u>8,070,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>13,221,700.00</u>	<u>8,070,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>13,221,700.00</u>	<u>8,070,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>13,221,700.00</u>	<u>8,070,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,221,700.00	8,070,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-13,221,700.00</u>	<u>-8,070,000.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,830,761.84	122,409,477.99	80,264,248.88	00.00	618,504,488.71
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	78,819,871.20	00.00	78,819,871.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	415,830,761.84	122,409,477.99	159,084,120.08	00.00	697,324,359.91
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өлз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	307,667,611.83	00.00	307,667,611.83
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,830,761.84	119,353,581.99	466,751,731.91	00.00	1,001,936,075.74
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,830,761.84	119,353,581.99	466,751,731.91	00.00	1,001,936,075.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	415,830,761.84	119,353,581.99	466,751,731.91	00.00	1,001,936,075.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өлз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	126,719,025.12	00.00	126,719,025.12
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,830,761.84	119,353,581.99	593,470,757.03	00.00	1,128,655,100.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Лөгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	422,445,800.00	400,486,462.47	21,959,337.53	94.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,445,800.00	400,486,462.47	21,959,337.53	94.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,513,000.00	384,553,662.47	21,959,337.53	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,098,200.00	259,232,485.57	5,865,714.43	97.8
210101	Үндсэн цалин	211,477,000.00	204,035,433.95	7,441,566.05	96.5
210102	Нэмэгдэл	53,621,200.00	39,262,207.62	14,358,992.38	73.2
210104	Урамшуулал	00.00	15,934,844.00	15,934,844.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,223,200.00	32,575,149.25	648,050.75	98.0
210201	Тэтгэврийн даатгал	22,811,800.00	22,371,118.81	440,681.19	98.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,602,900.00	2,551,007.30	51,892.70	98.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,082,300.00	2,040,866.43	41,433.57	98.0
210204	Ажилгүйдлийн даатгал	521,200.00	510,141.86	11,058.14	97.9
210205	Эрүүл мэндийн даатгал	5,205,000.00	5,102,014.85	102,985.15	98.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,650,000.00	29,252,843.65	2,397,156.35	92.4
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,270,689.65	229,310.35	90.8
210302	Түлш, халаалт	29,000,000.00	26,897,154.00	2,102,846.00	92.7
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	85,000.00	65,000.00	56.7
2104	Хангамж, бараа материалын зардал	24,700,000.00	23,389,271.00	1,310,729.00	94.7
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	14,500,000.00	13,626,200.00	873,800.00	94.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,900,000.00	4,275,611.00	-375,611.00	109.6
210404	Ном, хэвлэл	300,000.00	274,960.00	25,040.00	91.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	712,500.00	787,500.00	47.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,746,200.00	3,746,200.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,746,200.00	3,746,200.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	940,000.00	60,000.00	94.0
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	940,000.00	60,000.00	94.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,095,400.00	23,619,503.00	5,475,897.00	81.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,413,400.00	22,375,700.00	5,037,700.00	81.6
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	66,000.00	184,000.00	26.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	247,474.00	2,526.00	99.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	22,829.00	109,171.00	17.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900,000.00	767,500.00	132,500.00	85.3
210807	Газрын төлбөр	150,000.00	140,000.00	10,000.00	93.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18000000.00	11798210.00	6,201,790.00	65.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,000,000.00	11,798,210.00	6,201,790.00	65.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15932800.00	15932800.00	0.00	100.0

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	15,932,800.00	15,932,800.00	0.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,432,800.00	15,432,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	422,445,800.00	400,486,462.47	21,959,337.53	94.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	421,445,800.00	399,436,962.47	22,008,837.53	94.8
132001	Орон нутгийн төсвөөс	421,445,800.00	399,436,962.47	22,008,837.53	94.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,049,500.00	-49,500.00	105.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	49,500.00	-49,500.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26.00	26.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	08.00	08.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	04.00	04.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		28,420,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		28,420,150.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		25,968,508.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		62,208.85
210301	Гэрэл, цахилгаан		62,208.85
2104	Хангамж, бараа материалын зардал		2,327,400.00
210401	Бичиг хэрэг		35,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,928,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		30,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		334,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,126,000.00
210604	Урсгал засвар		1,126,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,961,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,961,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		18491500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		18,491,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		575500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		575,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		575,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,876,141.15
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		1,876,141.15
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		28420150.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		28,420,150.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		620,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,340,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		23,459,350.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааг иргэдэд хүргэх, төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тус байгууллага нь албан хаагчдын хэвийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг ханган төрийн үйлчилгээг чанартай, шуурхай хүргэж орон нутагтаа сайн сайхан, эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэн улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэн үйл ажиллагаагаараа үргэлж манлайлсан аймгийн тэргүүний Тамгын газар байхад оршино гэсэн зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Төсвийн орлогыг нэр төрлөөр нь биелүүлэх зорилт
- Төсөв санхүүгийн ил тод байдал, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах
- Төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалтыг сайжруулах зорилт
- Төсвийг үр ашигтай зарцуулж нэмж өр, авлага үүсгэхгүй байх зорилт
- Төсвийн хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлж, гүйцэтгэлийг хангах

ЗДТГ-ын дарга нь Төмөрбулаг сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 96 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу ЗДТГ-ын даргын 2018 оны 06 сарын 20 өдрийн А/11 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан цаг ашиглалт, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын нэг, хоёрдугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд төсвийн шууд захирагч буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу

бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол, соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 134,634.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	2,041.0	2,041.0
Бараа материал	117,390.1	148,782.4	31,392.
Үндсэн хөрөнгө	891,745.9	978,700.3	86,954.3
Нийт хөрөнгө	1,009,136.1	1,129,523.7	120,387.6
Өр төлбөр	7,200.0	868,600.0	-6,331.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,001,936.1	1,128,655.1	126,719.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,009,136.1	1,129,523.7	120,387.6

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Авлагын үлдэгдэл нэмэгдсэн шалтгаан нь нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 1,876.1 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн 334.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь нөлөөлсөн байна.
2. Бараа материалын дансны үлдэгдэл нэмэгдсэн шалтгаан нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн тамгын газрын барилгын засварын материал 14,000.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал дансанд 60,759.4 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 36,043.9 мянган төгрөгийг худалдан авч 69,207.2 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсантай холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нэмэгдсэн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 12,433.0 мянган төгрөгийн 4 мотоцикл, ОНХС-ийн хөрөнгөөр 68,360.0 мянган төгрөгийн ковш, мах ногоо борлуулах байр 15,000.0 мянган төгрөг, 18,000.0 мянган төгрөгийн 2 ухаалаг худаг зэрэг хөрөнгүүд нэмэгдсэнтэй холбоотой байна.
4. Өр төлбөр өмнөх оноос буурсан нь байгууллагад төлөх зураг төсвийн үнээс 6,520.8 мянган төгрөгийг барагдуулсантай холбоотой байна.
5. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл нэмэгдэхэд тайлант онд нэмэгдсэн хөрөнгийн дүн нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 492,255.8 мянган төгрөгийг, үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 86,325.0 мянган төгрөгийн төсвийг хасаж 406,930.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 15,150.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 421,455.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 421,445.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 1,049.5 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 400,486.5 мянган төгрөг буюу 64.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 21,959.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	408,889.1	386,880.3	22,008.9	94.6
2	Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх	13,606.2	13,606.2	-	100.0
	Үндсэн үйл ажиллагааны орлого		49,500.0	-49,500.0	
	Дүн	422,445.8	400,486.5	21,959.3	94.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 3,866.8 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хамтарсан багийн дэмжлэгт 474.0 мянган төгрөг, цахим тендерийн бичиг баримтын үнэ 364.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 23,715.8 мянган төгрөг нийт 28,420.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Байр ашиглалттай холбоотой зардалд 62.0 мянган төгрөгийг, хангамж бараа материалын зардалд 2,327.4 мянган төгрөгийг, урсгал засварын зардалд 1,126.0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 3,961.4 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 18,491.5 мянган төгрөгийг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд 575.0 мянган төгрөгийг зарцуулж зарцуулагдаагүй 1,876.1 мянган төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/13 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 9,211.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,908.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь Цалин шимтгэлийн зардлыг 6,513.8 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 2,397.2 мянган төгрөгөөр, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 5,475.9 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 6,201.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 355,400.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	355,400.0	2	355,400.0	100
Нийт дүн	2	355,400.0	2	355,400.0	100

Өмнөх оны 355,400.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,657.2 мянган төгрөгийн 5 алдаа 1 зөрчил илэрсэн. Аудитын явцад 46,657.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналтай холбоотой 5 алдааг залруулж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг тогтоож үнэлэх 1 зөвлөмжийг өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Материаллаг хэмжээний зөрчил илрээгүй тул төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн байдлын тайланд 121,853.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй боловч элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй 173 ширхэг үндсэн хөрөнгийг тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС-17 Параграф 49, УСНББОУС-31 Параграф 78, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т “Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээсээ материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ” гэж заасантай нийцэхгүй байгаа ба нягтлан бодох бүртгэлийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: УСНББОУС-17, 31, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу дансны үнэ бодит үнээсээ материаллаг зөрүүтэй байгаа биет болон биет бус хөрөнгийг дахин үнэлэх, цаашид ашиглах боломжгүй бол данснаас хасах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн алдаа	5	46,657.2			5	46,657.2	5	46,657.2				
Дүн	5	46,657.2			5	46,657.2	5	46,657.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой	1						1					
Дүн	1						1					

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО: